



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 495

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.4, 6.6 дахь заалт, 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Үйлдвэрлэл технологийн сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй нийт 15,000,000.00 (арван таван сая) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашиныг акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Шинжлэх ухаан технологийн их сургуулийн захирал Б.Очирбатад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг хууль тогтоомж, журмын дагуу Байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Акталж, данснаас хассан автомашины улсын дугаарыг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолт, дээрх арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 10 дүгээр сарын 08-ны өдрийн
495 дугаар тогтоолын хавсралт

**ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН
СУРГУУЛИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТЛАЖ ДАНСНААС
ХАСАХ АВТОМАШИН**

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн /ашиглалтад/ орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл
				/төгрөг/
1	E50 загварын Ниссан Илгранд, 5059 УНО, суудлын, КН-АТЕ50, 9660, АТЕ50032719	2002/2011	181100	15,000,000.00
Нийт дүн				15,000,000.00
				(арван таван сая)